

Радио нэвтрүүлэг дэх дүрслэлийн нөлөө

Л. Амарзаяа*

* РТДС-ийн тэнхмийн эрхлэгч, магистр

Уран зохиол, сэтгүүл зүй болон тайз, дэлгэцийн бүтээлийн судлалд зураглал, дүрслэлийг чухалчилдаг бөгөөд энэ нь радио сэтгүүл зүйн чиглэлд онцгойлон үзэх асуудал байдаг. Радио нь дүрслэлээр дамжуулан сонсогчдод төсөөлөл бий болгодог "Сонсох урлаг" билээ. Дүрслэлийг чухам яаж, хэрхэн илэрхийлэх нь радиогийн уран сайхны асуудалтай шууд хамааралтай юм.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ) дотор ямар ч цаг хугацаанд хэнийг ч хаана ч аваачиж, юуг ч дүрслэн илэрхийлж болох боломжтой бөгөөд хамгийн хүртээмжтэй, шуурхай хэрэгсэл бол радио мөн. Радиогийн мэдээллийн, задлан шинжилсэн, уран сайхны аль ч төрөлд дүрслэлийг чадварлаг илэрхийлж, сонсголоор нь дамжуулан сонсогчид тухайн орчинд очсон мэт сэтгэгдэл төрүүлж, үйл явдалд дагуулан хөтөлж болдог өвөрмөц онцлог бий. Энэ бол дүрслэлийн гайхамшиг, ололт билээ.

Радиогийн дүрслэл нь бодит болон уран сайхны гэсэн хэлбэртэй байх бөгөөд бодит дүрслэлийг мэдээллийн төрөлд дүрсэлсэн сурвалжлагын хэлбэрээр

ашиглах нь олонтаа. Харин уран сайхны дүрслэл нь уран сайхны нийтлэл, нэвтрүүлэг болон радио жүжиг, радио зохиомжийн чухал үндэс суурь болно.

Радиод дүрслэлийг бий болгодог элементүүд бий. Тэдгээрийн дотроос үгээр урлах, дуу хөгжмөөр болон чимээ шуугианаар илэрхийлэх нь гол бөгөөд эдгээр нь хоорондоо салшгүй хамаа-ралтай юм.

Үгээр урлах дүрслэл. Энэ нь радиогийн гол амин судас билээ. Сэтгүүл зүйд "зураглал нийтлэлийн болон уран сайхны гэсэн хоёр шинжийг зэрэг агуулахын хамт утга зохиолын шинжийг ч тодорхой хэмжээгээр илэрхийлдэг" (1.105) бол "найруулал нь нийтлэл, уран сайхны аргын нэгдлийн үр дүнд бий болдог хосолмол шинжтэй" (2.118) гэх мэтээр бичлэгийн төрлүүдэд дүрслэн илэрхийлэх асуудлыг хосолмол шинжтэй бөгөөд "уран зохиол, үгээр урлах, дүр бүтээх зохиолчийн ажлаас үүсэлтэй" (1.106) болохыг тодорхойлсон байдаг.

Үгийн оновчтой сонголт, зөв хуваарилалт, яруу уншилт нь радио сонсогчийн хүлээн авалтад шууд нөлөөлдөг. Зарим мэдээллийг шууд биш арай зөөлрүүлж, эсвэл ноцжуулж илэрхийлэх шаардлага

гарах бөгөөд ийм тохиолдолд дээрх нөлөөллийг харгалзан үзэх хэрэгтэй болно. Энгийн жишээ дурдахад манай сонсогчид анх хархны тухай мэдээлэл хүлээн авч байхдаа ихээхэн сүрдэн эмээж, болгоомжилж байсан. Энэ нь хархны тухай мэдээлэхдээ хүчрэгдэхгүй, аймшигт амьтан мэт сэтгэгдэл төрүүлэхээр дүрслэн мэдээлсэнд л байгаа юм. Би ч бас тийм сэтгэгдлээр хүлээн авсан сонсогчийн нэг мөн. Харин хүр хорхой бий болсныг дурдах төдийхнөөр мэдээлж өнгөрсөн. Гэтэл өнөөдөр хорхой гэлтгүй энэ амьтан ой модоор тархан сүйтгэж, зуны дэлгэр цагт зусланд гарсан айлуудын амар тайван байдлыг алдагдуулах боллоо. Уг нь хүр хорхойноос хэрхэн сэргийлэх, яаж устгах талаар мэдээлж таниулах нь илүү ач холбогдолтой байсан болов уу гэж санагдана.

Манайд радиогийн "дүрсэлсэн сурвалжлага"-ын төрөл харьцангуй ховорджээ. "Сурвалжлага гэдэг нэрийг бодсон ч зохиогч өөрөө явж олсон баримт, оролцсон үйл явдал байх ёстой" (2.38) бөгөөд сонсогч сурвалжлагчтай хамт тухайн үйл явдлын халуун цэг дээр биш ч, яг л тухайн газар очсон мэт сэтгэгдэл төрөхөөр орчныг дүрсэлж, хүмүүсийн байр байдлыг тайлбарлаж, болж буй явцыг зэрэгцэн цаг алдалгүй шуурхай илэрхийлж, нүдэнд харагдахаар дүрслэх нь "дүрсэлсэн сурвалжлага" болдог билээ. Тиймээс энэ

нь мэдээллийн төрөл зүйлийн өвөрмөц хэлбэр гэдгийг судлаачид онцолдог.

Үгээр зураглан дүрслэх нь радиогийн уран сайхны төрөл болох нийтлэл нэвтрүүлэг, радио жүжиг, радио зохиомжид давамгайл байдаг. Жишээ нь Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн С.Пүрэвийн "Сүүдэр догшрох цаг" (Ж-392) радио жүжигт дүрслэлийг үгээр гайхамшигтай урласан байдаг. "Эрээн мяраан хувцастай хүүхнүүд азарган тахиа шиг солонгорон

харагдаж" байгааг гаднах ижил төстэй шинжээр нь зүйрлэсэн ба "гэрлээр амилсан харанхуй", "дарсны хөх гэрэл тасалгаанд үхдэлийн сүнс мэт сүүдэлзэнэ", "тамхины гашуун утаа цээж рүү зовлонгийн дээж мэт гашуу оргиулан могойчлон гулсана" гэх мэтээр амьшуулсан дүрслэл сонсогчдод гүн сэтгэгдэл төрүүлж байгаа юм.

Үгээр зөвхөн бодит зүйлийг биш, бас оюун бодол, сэтгэл санаа гэх мэтийг илэрхийлж болдог бөгөөд энэ нь ялангуяа радиод дүрийн дотоод ертөнцийг нээх боломж олгодог. Радио нь сонсголоор дамжуулан хүний оюун ухаанд хүрч байдаг болохоор сэтгэхүйд хийсвэрлэлийг шууд бий болгодог онцлогтой. Радиогоор сонссон баатрын дүрийг сонсогч бүр өөрийнхөөрөө дүрсэлдэг байхад зурагтаар харсан дүрийг бүгд ижил хүлээн авдгаараа ялгаатай. Сайхан дүр, дүрслэлийг бий болгоход үгээр зураглах, илэрхийлэх

«

*Үгээр зөвхөн бодит
зүйлийг биш бас оюун
бодол, сэтгэл санаа гэх
мэтийг илэрхийлж болдог
бөгөөд энэ нь ялангуяа
радиод дүрийн дотоод
ертөнцийг нээх боломж
олгодог.*

»

чадвар чухал болохыг өмнө нэгэнтээ дурдсан билээ.

Дуу хөгжмөөр дүрслэх. Зөвхөн үгийн урлалаар мэдээлэл болон дүрслэлийг илэрхийлдэг гэвэл ташаа ойлголт болно. Зарим тохиолдолд үгээр өгүүлэх боломжгүй санаа, дүрслэлийг дуу хөгжим илэрхийлж чаддаг онцлогтой. Аль ч улс орны дуу хөгжим үйл явдал, түүх домгийг өгүүлсэн байдаг учраас үүнийг радиогийн нэвтрүүлэг болон радио жүжгийн баатрын дотоод сэтгэлийн илэрхийлэл болгон ашиглах нь шилдэг сонголт болдог байна. Бүр илэрхийлэх гэсэн санаагаа зориуд дуу болгон туурвисан байх нь ч бий. Энэ нь жирийн хэрэг биш, сонсогчийн сонсох эрхтэнд үгнээс дуу хөгжмөөр хүргэх нь илүү байдагтай холбоотой бололтой.

Мөн байгалийн зураглал, баяр хөөр, зовлон гуниг, бодол зэргийг ихэвчлэн хөгжмийн хөг аялгуугаар илэрхийлдэг. Энэ нь ч сонсогчид хүрч чаддаг. Энэ тухай нарийвчлан үзвэл урлаг, уран зохиолын судлалтай зайлшгүй холбогдох өргөн цар хүрээтэй асуудал болох билээ.

Чимээ шуугианаар дүрслэх. Сурвалжлагч газар дээрээс нь мэдээлж байна гэдгийг баталгаажуулах гол зүйл юу вэ? Мэдээж дуу чимээ, орчны шуугиан юм. Үүнийг шум гэж нэрлэдэг. Нөгөө талаар энэхүү чимээ шуугиан нь болж буй үйл

явдал бодитой үнэн болохыг нотлох баримт болно. Радиогийн уран сайхны нэвтрүүлэг болон радио жүжигт "утасны хонх дуугарлаа" гэхийн оронд утас дуугарах чимээ хамгийн хялбар илэрхийлэл болж чадна. Энэ мэтээр машины дохио, хаалга онгойх, гүйлдэх, аяга хагарах гээд дуу чимээг өргөн ашигладаг. Гэхдээ чимээ шуугианыг ашиглахад бас учир бий. Жишээ нь, радиогийн нэг сэтгүүлч адуу давхилдаж байгаа чимээг дэвсгэрлэхээр

төлөвлөж нэвтрүүлгийн эх бичврээ гаргажээ. Эх бичвэрт хавар цагийн адууны чимээ холбогдох ёстой байдаг. Гэтэл бэлэн байсан адууны чимээ нь намар цагийн бичлэг байлаа. Үүнийг яаж мэдэв? Тэрхүү чимээний дотор царцааны дуу сонсогдоноор намрын бичлэг болохыг мэдсэн байна.

Хавар царцаа байдаггүй билээ. Иймд аливаа чимээ шуугианыг радиод ашиглахын тулд онож сонгох зайлшгүй шаардлагатай байна.

Радиод чимээ шуугиан нь үйл явдлыг илэрхийлж байдгаараа онцлог билээ. Тиймээс ч радиог "Дуу чимээний урлаг" гэх нь цөөнгүй байдаг. Тухайлбал, "Цэргүүд хүндэтгэлийн жагсаалд жавхаалаг сайхан алхаж байна" гэхийн оронд тэрхүү алхааг нь сонсох л хэрэгтэй. "Хөхөөн дуу чихнээ тодхон сонсогдоно" гэхийн оронд хөхөө шувууны донгодох

«

Радиод чимээ шуугиан нь үйл явдлыг илэрхийлж байдгаараа онцлог билээ. Тиймээс ч радиог "Дуу чимээний урлаг" гэх нь цөөнгүй байдаг. Тухайлбал, "Цэргүүд хүндэтгэлийн жагсаалд жавхаалаг сайхан алхаж байна" гэхийн оронд тэрхүү алхааг нь сонсох л хэрэгтэй.

»

чимээг ашиглах нь нэг талаар уран сайханжуулж улмаар сонсох сонирхлыг нэмэх бөгөөд нөгөөтэйгүүр сонсогчийн чихийг амраадаг байна.

Удаан хугацаагаар ярих, хөгжим-дөх, дуулахыг сонсоход сонсогчийн чих ядарч, цааш үргэлжлүүлэн сонсохоос татгалздаг. Сонсоход зориулан бичнэ гэдэг дүрслэлийг тодорхой илэрхийлэхээс эхэлдэг тул радиогийн сэтгүүлч дүрслэлийн дээрх хэлбэрүүдийг хослуулан зөв ашиглах шаардлагатай юм. Өнөөдөр FM буюу хэт богино долгионы радио станцууд олноор бий болж, сонсогч түмэндээ дуу хөгжим, мэдээлэл, танин мэдэхүй, сургалтын чиглэлээр олон сайхан нэвтрүүлэг бэлтгэн хүргэх болжээ. Гэвч "Радио-сонсох урлаг" улам бүр хүрээгээ тэлж байгаа өнөөгийн нөхцөлд радио сэтгүүл зүйн асуудал, ялангуяа радиогийн сэтгүүлч гэж хэн болох, радиогийн онцлогийг мэдэх, радиогийн дүрслэлийн асуудлыг чухалчлах нь зүй ёсны хэрэг болж байна. Иймд үгийн олон утгыг хэрхэн оновчтой сонгох, үгийн сангаас зөв ашиглах, үгийг утга шилжүүлэн хэрэглэх зэргээр эх хэлнийхээ үгийн болон өгүүлбэр зүйн яруу хэрэглүүрээр сонсоход үзсэн мэт сэтгэгдлийг төрүүлэхүйц "дүрслэл"-ийг илэрхийлэх нь радиод онцгой чухал нөлөөтэй юм.

Ишлэл

1. Зулькафиль М. 2002. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. УБ.
2. Норовсүрэн Л. 1994. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ.

3. С.Пүрэв. "Сүүдэр догшрох цаг" радио зохиомж. (Монголын Үндэсний Радиогийн "Алтан сан" Ж-392.)

Role and Influence of Description in Radioprogramm

Radio is the special classification for understanding of any information, which reach to listening organ. Special characteristic of the radio is that it can give a visual impression after hearing. This is visualisation. Therefore visualisation is relent not only to literature, theatre, journalism and screening but also to the radio studies.

Radio visualisation can be real and artistic, which used in real visualization information "visual interview". The artistic visualization is the important base for programs and radio dramas.

There are some elements, which express the radio visualization. The importance one is to do skilful by words and visual by visual by music and noise. These all connected, which could not be separated.

For student, researchers and working journalists who study for journalism should be trained in expression of visualization method. This is the main question in radio journalism.